МЭДЭЭ · 2021 оны 9-р сарын 28

ЦАГДАН ХОРИХ, БАРИВЧЛАХ, СААТУУЛАХ БАЙРАНД ШАЛГАЛТ ХИЙСЭН БАЙНА



Увс аймгийн прокурорын газраас аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байр болон Цагдаагийн газрын баривчлах, саатуулах байрны үйл ажиллагаа, нийтэд тустай ажил хийлгэх ял эдэлж буй ялтны ялын биелэлттэй танилцжээ.

Улмаар Ковид цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан баривчлах байранд халдвар хамгааллыг сайтар сахих, баривчлагдсан хүмүүст олгож байгаа хоолны илчлэгийг Хууль зүй дотоод хэргийн сайдын 2017 оны 246 дугаар тушаалаар батлагдсан "Баривчлах байрны дотоод журам"-д заасан 2800 килокалориос багагүй байх заалтыг мөрдөж ажиллахыг үүрэг болгож, биелэлтийг эргэж тооцохоор болсон байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2668